

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ТӨВ БАНК /МОНГОЛБАНК/-НЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Төв банк /Монголбанк/-ны тухай хуульд доор дурдсан агуулгатай 19³ дугаар зүйл нэмсүгэй:

“19³ дугаар зүйл. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагаанд хяналт тавих

1. Монголбанк виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагааг нь зохицуулах, албадлагын арга хэмжээ авахтай холбогдсон дүрэм, журам, заавар, аргачлал болон холбогдох бусад шийдвэр гаргаж, хэрэгжилтэд нь хяналт тавина.

2. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийг бүртгэх, түүний үйл ажиллагаанд хяналт тавихтай холбогдсон харилцааг Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулиар зохицуулна.”

2 дугаар зүйл. Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн Дөрөвдүгээр бүлгийн гарчгийн “... систем,” гэсний дараа, мөн бүлгийн 24 дүгээр зүйлийн гарчгийн “... систем,” гэсний дараа “виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч” гэж, мөн зүйлийн 1 дэх хэсгийн “системийн” гэсний дараа “, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн” гэж, мөн хэсгийн “систем,” гэсний дараа “виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч,” гэж, 25 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1, 2, 3, 5, 8, 25² дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтын “төлөөлөгч,” гэсний дараа “виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч,” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд доор дурдсан агуулгатай заалт нэмсүгэй:

1/3 дугаар зүйлийн 3.1.12 дахь заалт:

“3.1.12.виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуульд заасан үйл ажиллагаа.”

2/6 дугаар зүйлийн 6.1.12 дахь заалт:

“6.1.12.Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн 5.6.1-д заасан дүрэм, журмыг Монголбанкттай хамтран батлах”

3/6 дугаар зүйлийн 6.2.8 дахь заалт:

“6.2.8.виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагааны чиглэлээр Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуульд заасан.”

2 дугаар зүйл. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.11 дэх заалтын “4.1.8” гэсний дараа “, 4.1.10” гэж, 24 зүйлийн 24.1, 24.4 дэх хэсэг, 26 дугаар зүйлийн 26.3 дахь хэсэг, 27 дугаар зүйлийн 27.2, 27.3 дахь хэсэг, 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсгийн “эзэмшигч” гэсний дараа “, бүртгэлтэй этгээд” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.8 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“25.1.8.тусгай зөвшөөрөл эзэмшигч, эсхүл бүртгэлтэй этгээд хууль тогтоомжийг ноцтой буюу удаа дараа зөрчсөн тохиолдолд тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох, эсхүл бүртгэлээс хасах талаар Хороонд санал оруулах;”

4 дүгээр зүйл. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн гарчиг, 25 дугаар зүйлийн 25.1.1, 25.1.6 дахь заалт, 26 дугаар зүйлийн 26.1.1 дэх заалтын “эзэмшигчийн” гэснийг “эзэмшигч, бүртгэлтэй этгээдийн” гэж, 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсэг, 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсгийн “эзэмшигчид”

гэснийг “эзэмшигч, бүртгэлтэй этгээдэд” гэж, 26 дугаар зүйлийн 26.1.2 дахь заалт, 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсгийн “эзэмшигчээс” гэснийг “эзэмшигч, бүртгэлтэй этгээдээс” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл. Энэ хуулийг Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

МӨНГӨ УГААХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай заалт нэмсүгэй:

“4.1.10. виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч.”

2 дугаар зүйл. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсгийн “4.1.1” гэсний дараа “, 4.1.10” гэж, мөн хэсгийн “4.1.8” гэсний дараа “, 4.1.10” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Зөрчлийн тухай хуулийн Арван нэгдүгээр бүлэгт доор дурдсан агуулгатай 11.33 дугаар зүйл нэмсүгэй:

“11.33 дугаар зүйл.Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль зөрчих

1.Виртуал хөрөнгийн үйлчилгээг эрхэлсэн, эсхүл уг үйл ажиллагааг бүртгэлгүй эрхэлсэн бол хүнийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2.Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч өөрийн харилцагчийн тухайн үйлчилгээнд хамаарах виртуал хөрөнгө болон мөнгөн хөрөнгийн бүрэн бэлэн байлдлыг хангаж чадаагүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

3.Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч хуульд заасан мэдээллийг Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, тэдгээрийн хянан шалгагчид саадгүй, бүрэн гүйцэд, үнэн зөв гаргаж өгөөгүй бол хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

4.Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч, түүний удирдлага, холбогдох этгээд болон эрх бүхий албан тушаалтан, ажилтан нь Монголбанк, Санхүүгийн зохицуулах хорооны хянан шалгагчийг бүрэн эрхээ хэрэгжүүлэх нөхцөлөөр хангаагүй бол гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гучин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

5.Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч нь хуульд заасан шаардлага, эрх, үүргээ хангаж ажиллаагүй бол хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

6.Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч нь бүртгэлээс хасагдсан тохиолдолд харилцагчид нэн даруй мэдэгдээгүйгээс учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж

хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн 6.18 дахь заалтын “11.30,” гэсний дараа “11.33,” гэж, мөн хэсгийн 6.19 дэх заалтын “11.32” гэсний дараа “, 11.33” гэж тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГӨӨР БАРАА, АЖИЛ,
ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.9 дэх хэсгийн “банкны” гэснийг “банк, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН
ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5 дахь хэсэгт доор дурдсан агуулгатай дараах заалт нэмсүгэй:

“13.5.20. виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэх.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

УЛСЫН ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт дараах агуулгатай заалт тус тус нэмсүгэй.

1/“5.1.47.Санхүүгийн зохицуулах хороонд Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчээр бүртгэх.”

2/“19.1.10.Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчээр бүртгэхэд 40 000-80 000 төгрөг.”

2 дугаар зүйл. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн “14-20 дугаар зүйл,” гэсний “19.1.10,” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг